

**ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗАР
ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭ ҮНЭЛГЭЭ МЭДЭЭЛЛИЙН ХЭЛТЭС**

**ӨМНӨГОВЬ АЙМГИЙН ЭРҮҮЛ
МЭНДИЙН САЛБАРЫН 2025 ОНЫ
ЭХНИЙ 09 САРЫН СТАТИСТИК
МЭДЭЭНИЙ ДҮГНЭЛТ**

2025-10-07

1.ЭХ НЯРАЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

1.1 Төрөлт, хүүхдийн тусламж үйлчилгээ:

- Аймгийн хэмжээнд 9 сарын байдлаар нийт 830 амаржсан нь өнгөрсөн оны мөн үеэс төрөлт 61 төрөлт буюу 5.9%-аар буурсан. Нийт төрөлтийн 35 /4.2%/ охидын төрөлт эзэлж байгаа нь өнгөрсөн оноос 2-р буурсан ба дараах сумуудын охид төрсөн байна. Үүнд: / ШБ-3,Өо-4,Эх-5, Бд-1,Бу-3,Гт-3,Но-3,Нн-1,Сэ-1,Хб-2,Хү-1,Цц-8 /

Амьд төрсөн 838 хүүхдийн:

- 418 буюу 49.9% нь эрэгтэй
- 420 буюу 50.1% нь эмэгтэй

Амьгүй төрөлт 4 бүртгэгдсэн нь өмнөх оноос 2 тохиолдлоор нэмэгдсэн байна.

2500 граммаас доош бага жинтэй 44 амьд төрсөн нярай нийт амьд төрөлтийн 5.3% ийг эзэлж өмнөх оны мөн үеэс 1.9%-р нэмэгдсэн.

0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл (бодит тоо, 1000 амьд төрөлтөд)

	Үзүүлэлтүүд	2024-09 сар		2025-09 сар		өөрчлөлт
		Бодит тоо	түвшин	Бодит тоо	түвшин	
1	Амьгүй төрөлт	2	2.2	4	4.8	↑
2	Перинаталь эндэгдэл (Амьгүй төрсөн+168 цаг дотор эндсэн)	9	10.1	11	13.3	↑
3	Нярайн эндэгдэл (0-28 хоногтой)	0	0.0	6	7.2	↑
4	Нялхсын эндэгдэл (0-1 нас хүртэлх)	12	13.4	14	16.7	↑
5	1-5 насны эндэгдэл	1	1.1	4	4.8	↑
6	0-5 хүртлэх насны эндэгдэл	12	13.4	18	21.5	↑

0-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийн шалтгаан (бодит тоогоор)


Нас		Перинаталь үед үүссэн эмгэг		Уушги - зүрхний дутагшил		Бактерт мэнэн		Осол гэмтэл		Халдварт бус суулгалт		Төрөлхийн гажиг		Менингококкцеми, тодорхойгүй		Бүгд	
		2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025	2024	2025
1 хүртлэх нас	0-6 хоног	7	6		1											7	7
	7-28 хоног		6														6
	29-өөс дээш хоногтой						1	2		1		2				5	1
1-5 хүртлэх настай									3			1			1	1	4
Бүгд		7	12		1		1	2	3	1		3		1		13	18

- 0-1 хүртэлх насны хүүхдийн эндэгдлийг харъяаллаар нь авч үзвэл:
Гт-2, Цц-1, Цо-1, Бд-1, Бу-1, Эх-4, Но-1, Мн-1, Шб-2 тус тус эндсэн байна.
- 1-5 насны хүүхдийн эндэгдлийг харъяаллаар нь авч үзвэл:
Шб-2, Нн-1, Хү-1 тус тус эндсэн байна.

1.2 ЖИРЭМСЭН ҮЕИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

2025 оны эхний 9 сард 1013 жирэмсэн эмэгтэйчүүдийг хяналтанд авсан нь өмнөх оны мөн үеэс 71 жирэмснээр буурсан . Жирэмсний эрт үеийн хяналт **90.9%** болж өмнөх оны мөн үеэс **0.4%-р** нэмэгдсэн.

Жирэмсний хяналт
/2024,2025 оны эхний 9 сар, хувь



Жирэмсэн эмэгтэйчүүдийн БЗДХ-ын шинжилгээнд хамрагдсан байдлын авч үзвэл тэмбүү, ХДХВ халдвар илрүүлэх шинжилгээнд 100% хамрагдаж тэмбүүгийн халдварын 6 эерэг тохиолдол бүртгэгдэж эмчилгээнд хамрагдсан.


Заг хүйтэн илрүүлэх шинжилгээнд 92.5% хамрагдагдсан, трихомониаз илрүүлэх шинжилгээнд 91.8% нь хамрагдаж, эерэг тохиолдол бүртгэгдээгүй байна.

Үр хөндөлт:


Аймгийн хэмжээнд эхний 9 сард 298 үр хөндөлт бүртгэгдэж, өмнөх оноос 46 тохиолдлоор , 1000 амьд төрөлтөд 359.0 болж өмнөх оноос 25.3-оор тус тус буурсан үзүүлэлттэй байна. Өсвөр насны охидын үр хөндөлт- 22/7.4/% буюу өнгөрсөн оны мөн үеэс 2,2%-р өссөн байна. **/Бо-1,Сэ-1, Хб-1, Хх-1,Хү-1,Цо-1,Цц-2, Дз/ Эх-7,Шб-1,Өо-4/** сумдын охидууд тус тус үр хөндөлт хийлгэсэн байна.

Нийт үр хөндөлтийн 180 буюу 60.4 %-ийг эмээр, 118 буюу 39.6%-ийг багажаар хийсэн. Багажаар хийсэн үр хөндөлт өмнөх оны мөн үеэс 4.6%-аар нэмэгдсэн бол эмийн үр хөндөлт 4.6%-аар буурсан.

**Үр хөндөлт
(2024.2025 оны эхний 9 сараар, 1000 амьд төрөлтөд)**



**Үр хөндөлтийн зарим үзүүлэлтүүд
(2024.2025 оны эхний 9 сараар, хувиар)**



20 хүртэлх насны охидын эзлэх хувь


Эхийн эндэгдэл:

Эхний 9 сарын байдлаар эхийн эндэгдлийн тохиолдол бүртгэгдээгүй. Өмнөговь аймагт 2018 оноос хойш эх эндээгүй.

2. ХАЛДВАРТ БУС ӨВЧИН:

Халдварт бус өвчний 77804 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 5964 тохиолдлоор, 10000 хүн амд 10105.9 болж өмнөх оны мөн үеэс 585.4-р тус тус нэмэгдсэн.

**Хүн амын өвчлөлийн тэргүүлэх шалтгаан
(2024.2025 оны эхний 9 сар, 10000 хүн амд)**




3.ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ ҮЙЛЧИЛГЭЭ:

3.1 Стационарийн тусламж үйлчилгээ

Аймгийн хэмжээнд эхний 9 сарын байдлаар 12183 хүн эмнэлэгт хэвтэн эмчлүүлсэн нь өмнөх оны мөн үеэс 1395 хүнээр буурч, нийт 76406 ор хоног ашиглаж, дундаж ор хоног 6.3 байна. Хэвтэн эмчлүүлэгч 10000 хүн амд 1582.4 болж өмнөх оны мөн үеэс 217.0-оор буурсан.


**Хэвтэн эмчлүүлэгчдийн өвчлөлийн тэргүүлэх шалтгаан
(2024.2025 оны эхний 9 сар, 10000 хүн амд)**



2.1 Амбулаторийн тусламж үйлчилгээ

Амбулаторийн нийт үзлэг эхний 9 сарын байдлаар 318775 болж өмнөх оны мөн үеэс 14782 үзлэгээр нэмэгдсэн байна.

**Амбулаторийн үзлэгийн бүтэц
(2024.2025 оны эхний 9 сар, хувиар)**



Амбулаторийн үзлэгийн бүтцийг өмнөх оны мөн үетэй харьцуулвал:

Үзлэгийн төрөл	2024 оны 9 сар	2025 оны 9 сар	өөрчлөлт
Урьдчилан сэргийлэх үзлэг	24.6	23.5	(-1.1) ↓
Амбулаторит өвчний учир үзлэг	57.2	56.4	(-0.8) ↓
Идэвхитэй хяналтын үзлэг	10.7	13.0	(+2.3) ↑
Гэрийн идэвхитэй хяналтын үзлэг	5.4	5.1	(-0.3) ↓
Гэрийн дуудлага	2.1	2.0	(-0.1) ↓

2.2 ТҮРГЭН ТУСЛАМЖИЙН ҮЙЛЧИЛГЭЭ:

2025 оны эхний 9 сарын байдлаар түргэн тусламжийн 7717 дуудлага бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 7.9%-аар (609) нэмэгдсэн.

**Түргэн тусламжийн дуудлагын зарим үзүүлэлтүүд
(2024.2025оны эхний 9 сар,хувиар)**



2.3 НАС БАРАЛТ:

Аймгийн хэмжээнд нийт 219 хүн нас барсан нь өмнөх оны мөн үеэс 21 тохиолдлоор буюу 8.7%-аар буурсан.

Үзүүлэлтүүд	2024-09 сар	2025-09сар	Өөрчлөлт
нийт нас баралтад эмнэлгийн нас баралтын эзлэх хувь	23.8	33.8	(+10.0)
Эмнэлгийн нас баралтад хоног болоогүй нас баралтын эзлэх хувь	49.1	35.1	(-14)
Хоног болоогүй нас баралтад 8-24 цагийн дотор нас барсан хүний эзлэх хувь	28.6	34.6	(+6)

Нийт нас баралтын 33.8% (74)-нь эмнэлэгт нас барсан нь өмнөх оны мөн үеэс 10.0%-аар өссөн . Үүнд:


- Бүсийн оношилгоо эмчилгээний төвд 75.7% (56 тохиолдол)
- Сумын эрүүл мэндийн төвүүдэд 24.3% (18 тохиолдол) бүртгэгдсэн.

Эмнэлэгт хоног болоогүй нас баралт 26 бүртгэгдэж, эмнэлгийн нас баралтын 35.1%-г эзэлж, өмнөх оны мөн үеэс 14.0%-өөр буурч , **8-24 цагийн дотор нас барсан хүний эзлэх хувь 6.0%-аар нэмэгдсэн.**

Хоног болоогүй нас баралтын шалтгааныг авч үзвэл:

- Осол гэмтэл гадны шалтгаантай - 34.6% (9)
- Зүрх судасны өвчний шалтгаантай-30.8% (8)
- Шээс ялгаруулах тогтолцооны өвчин-3.8%(1)
- Халдварт өвчний шалтгаантай - 7.7% (2)
- Хоол боловсруулах өвчин, элэгний хатуурал-3.8% (1)
- Шээс ялгаруулах тогтолцооны өвчин -3.8% (1)
- Нярайн эмгэг- 3.8% (1)
- Үжил-3.8% (1)
- Архины хордлого-7.7% (2) -ийг тус тус эзэлж байна,


Нас баралтын тэргүүлэх шалтгаан (2024.2025 оны эхний 9 сар, 10000 хүн амд)



3. ХАЛДВАРТ ӨВЧИН

1. Халдварт өвчний 1218 тохиолдол бүртгэгдэж 10000 хүн амд 158.2 промилль болж өмнөх оны мөн үеэс 13.6%-аар буурсан. Халдварт өвчний шалтгаант нас баралт -2 бүртгэгдсэн .


**Халдварт өвчний түвшин
(2024,2025 оны эхний 9 сар, бодит тоо, 10000 хүн амд)**



Халдварт өвчний бүтцийн хувьд авч үзвэл :



Нийт халдварт өвчний 432 /35.5%/-г БЗДХ, 200 /16.4%/-г салхинцэцэг, 379 /32,6%-г улаанбурхан өвчин, 72 /6,2%/-г хоолны хордлого, 33 /2,7%/-г цусан суулга, 18 /1,5%/-г улаан эсэргэнэ, 53 /4.4%/-г гар хөл амны өвчин, 5 /0,5%/-г ёлом, 17 /1,4%/-г сүрьеэ, 2 /0,2%/-г вируст гепатит, 4 /0,3%/-г сальмонеллт, 1 /0,1%/-г арьс мөөгөнцөртөх өвчин, 1 /0,1%/-г халдварт эритема, менингококкцеми тодорхойгүй-1 зэрэг өвчнүүд тус тус эзэлж байна

**Халдварт өвчний шинэ тохиолдол
(2024.2025 оны эхний 9 сар, 10000 хүн амд)**



4.ОСОЛ ГЭМТЭЛ :

Осол гэмтлийн өвчлөлийн 1321 бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 65 тохиолдлоор, 10000 хүн амд 171.6 промиль болж өмнөх оны мөн үеэс 15.7-оор тус тус буурсан.



Хүүхдийн осол гэмтэл, хордлого, гадны шалтгаант өвчлөлийн байдал:

Нийт осол гэмтлийн өвчлөлийн -17.6% (233) ийг 0-15 хүртлэх насны хүүхэд эзэлж өмнөх оны мөн үеэс 0.8%-аар буурсан.

15 хүртлэх насны хүүхдийн өвчлөлийн 29.6%-ийг 0-5 хүртлэх насны хүүхдийн осол гэмтэл (69) эзлэж өмнө оны мөн үеэс 2.1%-аар нэмэгдсэн байна.

5 хүртлэх насны хүүхдийн осол гэмтэл, гадны шалтгаант өвчлөлийн бүтэц


ӨОУА-10	2024-09	2025-09	өөрчлөлт
Түлэгдэлт /W85-X19/	37.1	23.2	13.9 ↓
Бүх төрлийн уналт/W00-W19/	14.3	27.5	+13.2 ↑
Зам тээврийн осол/V00-V99/	18.6	17.4	-1.2 ↓
Амьгүй механик хүчинд өртөх/W20-W49/	18.6	15.9	-2.7 ↓
Санамсаргүй хордох, хорт бодист өртөх /X40-X49/	1.4	0.0	0.0 ↓
Хүчирхийлэл /X85-Y09/	2.9	4.3	+1.4 ↑
Хорт амьтан ургамалд өртөх /X20-X29/	1.4	0.0	0.0 ↓
Амьтай механик хүчинд өртөх/W50-W64/	5.7	8.9	+3.2 ↑
Амьсгал боох аюултай бусад осол /W75-W84/	0.0	2.9	+2.9 ↑

Осол гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралт:

Осол гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралтын 38 тохиолдол бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеээс 9 тохиолдлоор нэмэгдсэн.

Нийт нас баралтын 17.4%-ийг эзэлж өмнөх оноос 5.3%-аар нэмэгдсэн

Осол гэмтэл, хордлого, гадны шалтгаант нас баралтын бүтэц (2024.2025 оны эхний 9 сараар, хувиар)



2025 оны 9 сарын байдлаар зам тээврийн ослын шалтгаант нас баралт өмнөх оны мөн үеэс 18.0%-р нэмэгдсэн.

Архины хордлогын 7 тохиолдол бүртгэгдснээс 3 хүн, амиа хорлохыг завдсан тохиолдол 16 тохиолдол бүртгэгдснээс 7 хүн нас барсан байна.

АНХААРАЛ ТАТСАН ҮЗҮҮЛЭЛТҮҮД:

1.1000 амьд төрөлтөд нялхсын эндэгдэл өмнөх оны мөн үеэс 2 тохиолдлоор нэмэгдсэн.

2.1-5 насны хүүхдийн эндэгдэл 4 бүртгэгдсэн ба осол гэмтлийн шалтгаантай-3, халдварт өвчний шалтгаантай-1 байна.

3.БЗДХ-ын 432 тохиолдол бүртгэгдсэн ба үүнээс өсвөр насны /14-19/ хүүхдийн 81 тохиолдол бүртгэгдсэн байна.

4.Халдварт өвчний шалтгаант нас баралт -2 бүртгэгдсэн байна.

		Эрт илрүүлгийн мэдээ 2025.9 сар																	
Эмнэлгийн нэр		Артерийн даралт ихсэх өвчний эрт илрүүлэг			Чихрийн шижингийн эрт илрүүлэг			Элэгний хавдарын эрт илрүүлэг/15-65/			Умайн хүзүүний эсийн шинжилгээ			Хөхний үзлэгт хамрагдсан хүн			Дундаж хувь		
		хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь	хамрагдвал зохих	хамрагдсан	хамрагдсан хувь			
1	Баяндалай	834	189	22.7	585	108	18.5	501	547	109.2	97	52	53.6	301	134	44.5	49.7		
2	Баян-овоо	797	403	50.6	931	373	40.1	951	476	50.1	79	50	63.3	251	160	63.7	53.5		
3	Булган	947	94	9.9	947	94	9.9	979	94	9.6	96	22	22.9	387	210	54.3	21.3		
4	Гурвантэс	2922	1263	43.2	1860	1069	57.5	1930	971	50.3	318	67	21.1	1423	250	17.6	37.9		
5	МандалОвоо	665	502	75.5	665	505	75.9	755	477	63.2	74	6	8.1	175	96	54.9	55.5		
6	Манлай	978	594	60.7	857	512	59.7	1132	717	63.3	139	64	46.0	403	231	57.3	57.4		
7	Номгон	1089	447	41.0	751	402	53.5	1181	479	40.6	88	24	27.3	310	91	29.4	38.4		
8	Ноён	877	708	80.7	586	543	92.7	876	818	93.4	97	44	45.4	336	183	54.5	73.3		
9	Сэврэй	646	482	74.6	440	344	78.2	814	336	41.3	90	49	54.4	291	117	40.2	57.7		
10	Ханбогд	2700	576	21.3	514	319	62.1	2625	1097	41.8	1970	122	6.2	1330	239	18.0	29.9		
11	Ханхонгор	918	212	23.1	616	204	33.1	970	424	43.7	94	103	109.6	321	235	73.2	56.5		
12	Хүрмэн	880	705	80.1	634	777	122.6	780	308	39.5	87	27	31.0	262	207	79.0	70.4		
13	ЦогтОвоо	1079	520	48.2	640	518	80.9	1175	740	63.0	111	20	18.0	345	158	45.8	51.2		
14	Цогтцэций	2800	386	13.8	2000	366	18.3	3000	1042	34.7	375	11	2.9	1550	354	22.8	30.9		
Сумын дүн		18132	7081	39.1	12026	6134	51.0	17669	8526	48.3	3715	661	17.8	7685	2665	34.7	38.2		
15	Шимбилэг	3116	1721	55.2	2409	1636	67.9	3188	934	29.3	684	162	23.7	1920	961	50.1	45.2		
16	ӨнөОрших	3116	943	30.3	2490	839	33.7	2527	1613	63.8	320	85	26.6	1020	474	46.5	40.2		
17	Энхийн хүслэн	3052	1635	53.6	2962	2147	72.5	2105	694	33.0	407	144	35.4	1534	822	53.6	49.6		
Өрхийн дүн		9284	4299	46.3	7861	4622	58.8	7820	3241	41.4	1411	391	27.7	4474	2257	50.4	44.9		
Нийт дүн		27416	11380	41.5	19887	10756	54.1	25489	11767	46.2	5126	1052	20.5	12159	4922	40.5	40.6		
9 сарын өссөн		27416	11380	41.5	19887	10756	54.1	25489	11767	46.2	5126	1052	20.5	12159	4922	40.5	40.6		

МЭДЭЭЛЭЛ БЭЛТГЭСЭН: ХШҮМХ-ийн статистикч О.Хандармаа, Ш.Нарандалай

